



Address: Golomt Bank, P.O.Box-22, Ulaanbaatar 210620A, Mongolia
Phone: (+976-11) 311971, 311530, Fax: (+976-11) 313155, 311958
SWIFT CODE: GLMTMNUB, E-mail: mail@golomtbank.com, www.golomtbank.com

2013.03.13

№03/464

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОР

..... ТАНАА

“Оюутны Эрдэм Шинжилгээний Бага Хурал”-ын тухай

Голомт банкнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Оюутны Эрдэм Шинжилгээний Бага Хурлыг 2013 оны 4-р сард 12 дахь удаагаа зохион байгуулах гэж байна.

Энэхүү ОЭШБХ нь Монгол Улсын ирээдүйд хувь нэмрээ оруулах оюутан залуусыг дэмжиж урамшуулах, сурч боловсрох, судалгааны ажил хийхэд нь дэмжлэг үзүүлэх, өөрсдийгөө нээж, бусдаар үнэлүүлэх боломж олгох зорилготой бөгөөд та бүхнийг бидний ажилд туслалцаа үзүүлэн хамтран ажиллана гэдэгт найдаж байна.



Голомт банкны Оюутны эрдэм шинжилгээний бага хуралд оролцох хүсэлтэй сургуулийнхаа шилдэг, манлайлагч, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд сонирхолтой бөгөөд авьяастай оюутнуудыг идэвхжүүлэн, тэднийг мэдээллээр хангах ажилд хамтран ажиллахыг хүсч байна. Үүнд:

1. Сургуулийн орчин талбайд анонс, зурагт хуудас байршуулах зөвшөөрөл олгох;
2. Сургуулийн вэб хуудсанд банкны зүгээс бэлдсэн ОЭШБХурлын тухай зар байршуулах;
3. Вебсайтдаа мэдээ мэдээлэл оруулан манай банкны веб хуудас руу линк байршуулах;
4. Багш, ажилтнууд, сургалтын алба гэх мэт шугамаар оюутнуудад мэдээлэл хүргэх зэргээр бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

ОЭШБХ-ын удирдамжийг Хавсралтаас үзнэ үү.


Хамтын ажиллагаанд талархан хүндэтгэсэн,

**ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН
ЗАХИРАЛ**



030853

БАТЛАВ.



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ Г.АРИУНБАЯР



**ГОЛОМТ БАНКНЫ АРВАН ХОЁР ДАХЬ УДААГИЙН
ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ**

Голомт банкнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Оюутны Эрдэм Шинжилгээний Бага хурал 2013 оны 4-р сарын 19-ны өдөр 12 дахь удаагаа зохион байгуулагдах гэж байгаа бөгөөд энэ удаагийн эрдэм шинжилгээний бага хурал нь банк санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлагын ерөнхий чиглэлээс гадна мэдээллийн технологийн асуудлыг хөндөж байгаагаараа илүү онцлогтой юм.

ЗОРИЛГО

Банк санхүүгийн байгууллагуудын тулгамдсан асуудлуудыг шийдэх, онол практикийн ач холбогдол бүхий судалгаа шинжилгээний ажил хийж хэрэгжүүлэх, шинэ оновчтой санаа, санаачлагыг гаргахад оюутнуудын оролцоог нэмэгдүүлэх, Голомт банкны ажилтнуудтай хамтран ажиллахыг дэмжих зорилготой.

СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Оюутны эрдэм шинжилгээний бага хурал нь Хөрөнгө оруулалтын, Санхүүгийн удирдлагын, Мэдээллийн технологийн, Эрсдэлийн удирдлагын, Зээлийн гэсэн ерөнхий 5 чиглэлийн сэдвийн хүрээнд явагдана. /Хавсралт 1/

ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хурал 2 үе шаттайгаар явагдах бөгөөд эхний үе шатанд ирүүлсэн нийт бүтээлүүдэд өгсөн шүүгчдийн үнэлгээгээр 2-р шатанд оролцох илтгэлүүдийг шалгаруулна.

1-р үе шат

- Бүтээлийн хэвлэмэл хувилбарыг оролцогчдын бүрдүүлсэн материалын хамт 2013 оны 4-р сарын 05-ны Баасан гаригийн 18.00 цаг хүртэл Бодь цамхагийн 2 давхарт байрлах Голомт банкны Хүний нөөцийн хэлтэст хүлээн авна.
- Бүтээлийн “Word” файлаарх хувилбарыг 2013 оны 4-р сарын 05-ны Баасан гаригийн 18.00 цаг хүртэл chinzorig_ch@golomtbank.com хаягаар хүлээн авна.
- Голомт банкны мэргэжилтнүүд болон их дээд сургуулийн төлөөллөөс бүрдсэн шүүгчдийн баг бүтээлүүдэд үнэлгээ өгч 2-р шатанд тэнцэх илтгэлүүдийг шалгаруулна.

2-р үе шат

- Хүний нөөцийн хэлтсээс мэдэгдсэн товын дагуу Монгол банкны хурлын танхимд шалгарсан бүтээлийн эзэд илтгэлээ тавина.

БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА :

1. Бүтээлийн агуулгын хувьд ;

- ✓ Онол, арга зүйн үндэслэлтэй ;
- ✓ Бодит байдалд хэрэгжиж болохуйц ;
- ✓ Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан ;
- ✓ Шинэлэг санаа дэвшүүлсэн ;
- ✓ Судалгааны шалгарсан болон шинэлэг арга хэрэгслүүдийг ашигласан ;
- ✓ Аливаа дүгнэлт, зөвлөмжийн шийдэл бүхий ;

2. Оролцогчдын хувьд:

- ✓ Оролцогч нь Монгол улсын Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн оюутан байна ;
- ✓ Багаар оролцож болох ба багийн гишүүдийн тоо 3-аас ихгүй байна ;
- ✓ Оролцогчид буюу багийн гишүүн тус бүр доорх материалуудыг бүрдүүлэн өгсөн байна. Үүнд :
 - Оюутны анкет ;
 - 1 хувь цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан, 3x4 хэмжээтэй/;
 - Сургуулийн тодорхойлолт ;
 - Бүтээлийн хэвлэмэл хувилбар ;

3. Илтгэлийн техник боловсруулалтын хувьд :

Фонт :	Times new roman / “mon” font байж болохгүй/
Фонтын хэмжээ:	12
Захын зай:	Орой хэсгээс – 1.5 см; Зүүн захаас –3 см ; Доод хэсгээс – 1.5 см; Баруун захаас – 1.5 см ;
Бүтээлийн хуудасны тоо:	20-50
Илтгэлийн слайдын тоо:	25-с илүүгүй /10 минутанд багтаан танилцуулахад тохиромжтой байх/
Бусад:	- Нүүр хуудсанд оролцогч сургууль, мэргэжил, курс, овог нэр, сэдвийн чиглэл, нэр, он бичсэн байх ; - Бүтээлийн хэвлэмэл хувилбарыг нуруулдах, үдэх хэлбэрээр хөдлөшгүй болгосон байх ;

ГОЛОМТ БАНК

ГОЛОМТ БАНКНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ-2013
ОЮУТНУУДААР СУДЛУУЛАХ СЭДЭВ

1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР
1.1. Кастодиан банк, клиринг банкны үйлчилгээ 1.2. Төрөл бүрийн хөрөнгө оруулалтын санг Монголд хөгжүүлэх боломж 1.3. Дотоод болон гадаадын зах зээлээс зардал багатай эх үүсвэр татах, санхүүжилт татах арга хэрэгслүүд 1.4. Эхлэлтийн болон дунд шатны компаниуд, том корпорациудын санхүүжилтын онцлог 1.5. Компаний үнэлгээ ба хувьцааны үнэлгээ хийх аргачлал 1.6. Улсын сан буюу “sovereign wealth fund” байгуулах, хөгжүүлэх 1.7. Монголын хөрөнгө оруулалтын орчин ба зээлжих зэрэглэл, Монгол улсын рейтинг 1.8. Хөрөнгийн Зах Зээлийг хөгжүүлэх боломж, арга зам 1.9. Төгрөгийн ханшийн эрсдэлийг бууруулах болон бусад үр ашигтай дериватив бүтээгдэхүүнүүд 1.10. Тэтгэврийн сан болон бусад урт хугацаат хөрөнгө оруулалтын оновчтой менежмент 1.11. Хөрөнгийн болон бондын зах зээлийг хөгжүүлэх боломж, Засгийн газрын бонд
2. САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР
2.1. Нягтлан бодох бүртгэлийн хяналтын систем, түүнийг сайжруулах арга зам 2.2. Байгууллагын дотоод хяналтын систем 2.3. Банкны актив, пассивын удирдлагыг боловсронгуй болгох 2.4. Банкуудын хадгаламж, зээлийн хүүг бууруулах боломж 2.5. Банкны эх үүсвэр нэмэгдүүлэх боломж
3. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР
3.1. Microsoft Excel дээр их хэмжээний өгөгдлийн боловсруулалт хийх оновчлол 3.2. Data mining болон ETL 3.3. Data Warehousing техникүүд болон Даймэшн загварчлал 3.4. Business Intelligence болон Open source BI програмууд 3.5. Програм хангамжийн тестчилэл, түүний төрлүүд 3.6. Програм хангамжийн чанарын менежмент 3.7. Big Data болон NoSQL өгөгдлийн сан 3.8. Бизнес процессын загварчлал болон програмууд 3.9. Мэдээллийн технологи бизнесээ хэрхэн хөтлөх вэ? 3.10. Систем (програм хангамж) хөгжүүлэлтийг бизнесийн зогсолтгүй өөрчлөлтөнд бэлэн байлгах 3.11. Систем (програм хангамж) хөгжүүлэгчид болон бизнесийн нэгжийн хамтын ажиллагааг сайжруулах
4. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР
4.1. Банкны эрсдэл, түүнийг тооцох, үнэлэх шинэлэг аргууд, түүний удирдлага 4.2. Үйл ажиллагааны эрсдэлийг оновчтой аргаар удирдах нь 4.3. Зээлийн багцын эрсдэлийн удирдлага 4.4. Зах зээлийн эрсдэлийг оновчтой удирдах нь /Хүү, ханш, хөрвөх чадвар/ 4.5. Үйл ажиллагааны эрсдэлийг давтамжийн загвараар үнэлэх нь 4.6. Банкны зээлийн эрсдэлийг хэмжих, үнэлэх аргачлал, нөлөөлөгч хүчин зүйл 4.7. Зээлийн мониторингийн бусад орны туршлага, хөгжүүлэх арга боломж 4.8. Зээлийн эрсдэлийг эдийн засгийн салбаруудаар ангилж судлах 4.9. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг загварчлах, таамаглал боловсруулах аргачлал 4.10. Банкуудад үзүүлэх макро эдийн засаг, мөнгө сангийн бодлогын нөлөөлөл 4.11. Банкуудын стресс тест боловсруулах, арга аргачлал 4.12. Үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх аргачлалууд, тэдгээрийн хэрэглээ, банкинд хэрэгжүүлэх боломж 4.13. Үйл ажиллагааны эрсдэлээс бий болсон алдагдал, дампуурсан тохиолдлууд, олон улсын туршлага, ач холбогдол, шалтгаан, үр дагавар 4.14. Банк, хөрөнгийн зах зээлд оролцох, зах зээлийн бүтээгдэхүүн гаргаснаас үүсэх үйл ажиллагааны эрсдэл, түүнийг удирдах нь 4.15. Эрсдэлийг удирдахад дотоод аудитын нөлөөлөл, бусад орны туршлага 4.16. Чанаргүй зээл ба бусад орны туршлага, сайжруулах арга аргачлал 4.17. Чанаргүй зээл болон барьцаа хөрөнгийн хамаарал 4.18. Хүний нөөцийн эрсдэлийн удирдлага 4.19. Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны өнөөгийн байдал, цаашид сайжруулах боломж, FATF-ийн стандартуудыг бүрэн хэрэгжүүлэхэд авах арга хэмжээ
5. ЗЭЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР
5.1. Банкны зээлийн эрсдэлийн удирдлага: Кредит рейтинг хөгжүүлэх, арга аргачлал 5.2. Банкны зээлийн эрсдэлийн удирдлага: Кредит скоринг хөгжүүлэх, арга аргачлал 5.3. Зээлийн багцын чанарыг тэргүүлэгч индикаторууд /leading indicator/ 5.4. Зээлийн хүүний тэргүүлэгч индикаторууд 5.5. ДНБ дэх зээлийн нэвчилт, түүний хүчин зүйл 5.6. Төслийн санхүүжилтийн арга хэлбэр 5.7. Монголд амжилттай хэрэгжиж буй SME бизнесийн чиглэл